



НОГООН ХӨГЖИЛ
ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ
ХУВЬЦААТ КОМПАНИ



2024
04.30-НИЙ

ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН МАТЕРИАЛ





НОГООН ХӨГЖИЛ
ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ
ХУВЬЦААТ КОМПАНИ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

№ ...

Улаанбаатар хот

Тов: Хувьцаа эзэмшигчдийн хурал 2024 оны 04 дүгээр сарын 30-ны мягмар гарагийн 14:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 18-р хороо Жавзандамбын гудамж Эл Эс плаза, 11 давхар 1102 тоотод болно.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх тухай
2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг танилцуулах тухай
3. Хувьцаа хуваах тухай.

--o0o--



НОГООН ХӨГЖИЛ
ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ
ХУВЬЦААТ КОМПАНИ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

2024 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

№ ...

Улаанбаатар хот

“Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 30-ны мягмар гарагийн 14:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 18-р хороо Жавзандамбын гудамж Эл Эс плаза, 2 давхар 204 тоот.

№	Агуулга	Хугацаа
1	Хурлын ирцийг бүртгэх /Комисс/	13:00-14:00
2	Хурлын ирцийг мэдээлэх /Комисс/	5 минут
3	Хурлыг нээх, хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулж батлах /хурлын дарга/	Цаг тогтоохгүй
4	Хурлын үндсэн асуудлуудыг хэлэлцэх	Цаг тогтоохгүй
5	Хэлэлцсэн асуудалтай холбоотой асуулт, хариулт	3 минут /1 хүн /
6	Хэлэлцсэн асуудлын талаар үг хэлэх, санал гаргах	3 минут
7	Санал хураалт	20 минут
8	Хурлын завсарлага	10 минут
9	Санал хураалтын дүн танилцуулах /тооллогын комисс/	10 минут
10	Хурлаас гарах шийдвэрийн тогтоолын төслийг танилцуулах , хэлэлцэж батлах	10 минут
11	Хурлыг хаах /Хурлын дарга/	5 минут

-ооо-



НОГООН ХӨГЖИЛ
ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ
ХУВЬЦААТ КОМПАНИ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ОРОЛЦОХ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧИГ

2024 оны 4 дүгээр
сарын 30 -ны өдөр

№ ...

Улаанбаатар хот

“Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах болсонтой холбогдуулан тус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд дараах бичиг баримтыг танилцуулна.

- Компанийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай тогтоол
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
- Кампанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлаар санал авах хуудасны загвар
- Ээлжит хурал зарласантай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн зайлшгүй мэдэх ёстой бусад мэдээлэл

-о0о-



**"НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар.....

Эзэмшиж буй хувьцааны тоо.....

Бүртгэсэн үнэт цаасны компанийн нэр.....

Брокерийн овог.....нэр.....

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлэсэн
1	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх тухай			
2	Ногдол ашиг хуваарилахгүй тухай төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг танилцуулах тухай			
3	Хувьцаа хуваах тухай			

Брокер.....Гарын үсэг

/тэмдэг/

Хувьцаа эзэмшигч.....Гарын үсэг



**“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 4 дүгээр
сарын 30 -ны өдөр

№ ...

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ ХЭЛЭЛЦЭХ ТУХАЙ**

Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 7.7.2, Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Ж.ЖАРГАЛСАЙХАН



НОГООН ХӨГЖИЛ
ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ
ХУВЬЦААТ КОМПАНИ



2023

Тайлан



Агуулга



1. Компанийн засаглал

2. Компанийн үйл ажиллагаа

3. Санхүүгийн мэдээ тайлан

4. Онцлох арга хэмжээ

1. БНХАУ-ын Тяньжин хотноо Монгол-Оросын олон улсын худалдааны Тяньжин компани байгуулав.
2. Хувьцаат орон сууц хөтөлбөрийг тусгаарлав.
3. 2 удаагийн Road show зохион байгуулав.
4. Эрээн хотод 3 улсын хамтарсан компани байгуулав.
5. colliers international хамтран ажиллах гэрээ зурав.
6. ОХУ-ын “НПО ЭМ-Центр” ХХК-тай байгуулав.





ТҮҮХЭН ТОВЧОО

Жаргалант сумын Худалдаа үйлчилгээний төв

XX зууны Монгол улсын аж үйлдвэрийн томоохон бүтээн Уулын баяжуулах үйлдвэрийг түшиглэсэн шинэ хотын хүн амыг мах, сүү, төмс хүнсний ногоогоор хангах зорилгоо 1975 онд Улаантолгойн сангийн аж ахуйг Эрдэнэт хотоос 30 орчим км-ийн зайд орших Жаргалант суманд байгуулжээ. Тус сангийн аж ахуйн олон барилга байгууламжийн нэг нь тухайн үеийнхээ хамгийн сүүлийн төхөөрөмжөөр тоноглогдсон агуулах, нийтийн хоолны газар, дэлгүүр бүхий худалдаа үйлчилгээний төв байсан нь манай компанийн анхны үүсгэл болсон билээ.

“Жаргалант-Үйлс” ХК

1991 оны 12 сарын 23 өдрийн Эрдэнэт хотын Өмч хувьчлалын комиссын 20 дугаар тогтоолоор тус худалдаа үйлчилгээний төвийг бүрэн хувьчилж “Жаргалант-Үйлс” ХК болгон зохион байгуулсан байна. Тус хувьцаат компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө 5205600 /таван сая хоёр зуун таван мянга зургаан зуун/ төгрөг, нийт гаргасан хувьцааны тоо 52056 /тавин хоёр мянга тавин зургаа/, регистрийн дугаар 2051834, улсын бүртгэлийн дугаар 2010001003, үнэт цаасны код JLT(201) байлаа.





ТҮҮХЭН ТОВЧОО

2016 оны 06 сарын 02-ны өдрийн хувьцаа эзэмшигчдын хурлаас 01/01 тоот тогтоол гарган “Жаргалант үйлс” ХК-ийн дүрмэнд өөрчлөлт оруулж “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК болгон өөрчлөн зохион байгуулахаар шийдвэрлэв.

Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2016 оны 10 сарын 04 өдрийн 369 тоот “Хувьцаат компанийн нэр өөрчлөх тухай” тушаалаар “Жаргалант үйлс” ХК-ийн оноосон нэрийг “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК болгон өөрчилж Монголын Хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэгдэв.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2016 оны 12 сарын 01 өдрийн 287 тоот “Жаргалант үйлс” ХК-ийн оноосон нэрийг “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК болгон үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах тухай” тушаалаар улсын бүртгэлд шинэчлэгдэн бүртгэгдэв.

2016 оны жилийн эцсийн тайлан тэнцлээр Орхон уул аймгийн татварын албанд бүртгэлтэй “Жаргалант үйлс” нэрээр явуулж байсан үйл ажиллагааг дуусгавар болгон 2017 оноос Улаанбаатар хотод шилжин шинэ чиглэл, зохион байгуулалтаар ажиллаж эхлэв.





Бидний тухай

Дэлхийн ногоон хөгжил буюу цэвэр, тогтвортой хөгжлийн бодлого, зорилгыг монгол хөрс, монгол ахуй, монгол сэтгэхүйд буулгаж, нийхэмийн цөм болсон ХҮН-д нь ойртуулах, эерэг үр дүнг бүгдэд хүртээмжтэй болгох үүднээс үндэсний уламжлал, өв соёл, орчин цагийн онцлогийг зөв хослуулсан үйл ажиллагааны үзэл баримтлал, зарчим, зорилго зорилтуудыг боловсруулан тэдгээрт чиглэгдсэн хөтөлбөр, төслүүдийг амжилттай хэрэгжүүлж ХАМТДАА ХӨГЖИНӨ.

Эрхэм зорилго

Бид “Эх болсон цэнхэр гаригаа энгүй сайхнаар нь ирээдүй хойчдоо өвлүүлэн үлдээх” чин үнэн, цор ганц эрхэм зорилгын дор нэгдсэн бөгөөд хэн байх, хаана байх, хэзээ байхаас үл хамааран бүх нийтийн үйл хэрэг болгох учиртай. Өвөг дээдсийнхээ үүсгэсэн эх дэлхийгээ хайрлан хамгаалах үйлийг үргэлжлүүлж, өнөөдрийн амжилтыг цогцлоож, ирээдүйгээ сайхан болгох нь манай хамтын амжилтын үндсэн тулгуур байх болно.

Алсын хараа

Эрдэм авьяасаараа бусдадаа тус дэм болдог, хүрээлэн байгаа орчноо хайрлан хамгаалдаг зуун мянган хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшигчидтэй хүчирхэг, найрсаг хамт олон, арван их наядын үл хөдлөх хөрөнгө болон эргэлтийн хөрөнгөтэй, тогтвортой эдийн засагтай компани болон хөгжинө.





Бидний үнэт зүйлс

Нэр төр, билэгдэл нандин чанар

Ногоон-цэвэр дөрвөн өв, хөгжил-үүслийн үргэлжлэл, үндэсний-нүүдлийн монгол ахуй, нэгдэл-хамтын зүтгэл зорилтуудаар билэгдсэн компанийнхаа нэр хүндийг ямагт эрхэмлэн дээдэлнэ.

Ил тод байдал

Олон нийтийн компанийн хувьд шаардлагатай бүх мэдээллийг нийтэд ил тод байлгаж, хувьцаа эзэмшигчдэд жилд ганц удаа биш улирал тутам тайлагнадаг, ногдол ашиг хуваарилдаг тогтолцоог бүрдүүлнэ.

Сайн засаглал

Бүгдээр хэлэлцэж оновчтой шийдвэр гаргадаг, гаргасан шийдвэрээ ягштал хэрэгжүүлдэг, бодлого үйлдэл үр дүн нь төгс нийцдэг засаглалын тогтолцоог бүрдүүлнэ.

Бүх нийтийн оролцоо

Хувьцаа эзэмшигч бүр компанийн үйл ажиллагаанд биечлэн оролцох боломжоор хангагдаж хариуцсан ажилдаа эзний ёсоор ханддаг болж хэвшинэ.

Эв нэгдэл

“Эвт шаазгай буга барьдаг” ардынхаа мэргэн сургаалыг суурь болгон эвлэлдэн нэгдэж хамтын хариуцлага нэгдсэн үнэ цэнийг бий болгож ажиллана.

Шударга зарчим

Хувьцаа эзэмшигч бүр компанийн үйл ажиллагаанд оролцсон оролцооныхоо дагуу хариуцлага хүлээж түүндээ нийцсэн үр дүнг хүртдэг байна.





Бидний үнэт зүйлс

Итгэл сэтгэл

“Та ирээдүйгээ харж чадвал түүнийгээ бүтээж чадна” гэсэн зарчимаар компанийнхаа бодлого, зорилгыг гүнээ ухамсарлан ойлгож төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэхийн төлөө хамт ажиллах итгэл сэтгэл зүтгэлтэй байна.

Найрсаг, нөхөрсөг ёс

Бие биедээ хүндэтгэлтэй, хүлээцтэй, найрсаг ханддаг дэг жаягтай, нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлсэн соёл үнэт зүйлтэй байгууллага, хамт олон байна.

Тогтвортой байдал

Компанийн үйл ажиллагааг 20, 10, 5 жилээр төлөвлөж урт удаан хугацаанд тогтвортой, бүх эзэмшигчид, хамтран ажиллагсдад ойлгомжтой байх нөхцөл бололцоогоор хангана.

Уламжлал, Шинэчлэл

Ахуй, өв соёлын онцлогоо хадгалж шинэ үеийн ололт амжилтыг соргоогоор хүлээн авч нэвтрүүлдэг байна.

Дэг журам

Дүрэм журмыг нийтээрээ чандлан сахьдаг, эрх зүйн болон ёс зүйн хэм хэмжээгээр хийсэн үйлдэлдээ хувийн болон хамтын хариуцлага хүлээж чаддаг харилцааг хэвшүүлэн мөрдөнө.

Эрч, хүч, хурд

Нийтээрээ дагаж мөрддөг хэм хэмжээтэй байж. Бодлого, үйл ажиллагааг хурдтай хүчтэй эрчтэй байдаг зүй тогтолоор хөгжинө.

Хамтын хариуцлага

“Нэг хүн хариуцвал нэг үнэтэй олдвор, зуун хүн хариуцвал зүүн үнэтэй баялаг” хэмээх өвгүдийн ухаанд шимтэн бие биендээ тавих шаардлагаа өндөржүүлж, оролцогч бүр үүрэг хариуцлагаа ухамсарлан амьдарна.





АЛСЫН ХАРАА, ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ БИЗНЕСИЙН БҮТЭЦ, ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Алсын хараа, хөгжлийн зорилготойгоор үндэсний болон бүс нутгийн хэмжээний томоохон компани болно. Бид хамтдаа Монгол улсын иргэний газар өмчлөх, орон сууцаар хангагдах, ашиг орлоготой байх эрхүүдийг хамтын үүрэг хариуцлагад шилжүүлэн зүй зохистой эргэлтэд оруулснаар сайн засаглалтай, тогтвортой хөгжилтэй сонгодог хувьцаат компанийн үлгэр загварыг бий болгоно.





Хувьцаат орон сууц хөтөлбөрийг тусгаарлав

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Хувьцаат орон сууц хөтөлбөрийг
Тусгаарлан Өргөө ногоон хөгжил ХХК бие даан тус хөтөлбөрийг
Хариуцан бие даан үйл жиллагаа явуулж эхлэв



2023
Тайлан



Захиргаа, удирдлагын хэлтэс

Үйл ажиллагааны нэр	Хийгдсэн ажлууд
Дотоод зохион байгуулалтыг сайжруулах	<ul style="list-style-type: none">Шинэ ажилчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулан, хуучин ажилчидтай нөхөж хөдөлмөрийг гэрээ болон нүүцэн баталгаа байгуулав. Мөн 2022 оны хүний нөөцтэй холбоотой Б тушаалуудыг нөхөж гүйцэтгэх захирлаар батлуулав.Компанийн ажилчдын ээлжийн амралтын саналыг авч 2023.06.12-ны өдөр захирлаар батлуулав.
Хүний нөөцийн үр чадвар, мэдлэг, бие бялдарын хөгжлийг дэмжих үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none">Компанийн ажилчдын хувь болон багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэхийн хүрээнд хэд хэдэн сургалтыг 2023.06.05-2023.06.09-ний өдрүүдийн хооронд судалж, У.Хосбаяр багшийн Нүүдэлчин: “Өөрийгөө бүтээх, Өрөөлийг гэрэлтүүлэх” сэдэвт хувь хүний хөгжлийн сургалтыг Тэрэлж Бумбан түрт амжилттай зохион байгууллаа.2023 оны 12 дугаар сараас эхлэн ажилчдын бие бялдарын хөгжлийг дэмжих зорилгоор Хүрд спорт зааланд 14 хоногт заалт авч байхаар гэрээ байгуулав.Улсын болон хувийн эмнэлгүүдийг судалж, Б.Бямбабаяр эмчийн Хэвлийн хэт авиа оношилгоо /эхо/ , Биохимийн шинжилгээ, Хавдарын эмчийн үзлэг, Эрдэсийн /аппаратаар/ зэрэг 4 шинжилгээг сонгож, үзлэг, шинжилгээний цагийг авч ажилчдыг хамруулах ажлыг зохион байгуулсан.
Компанийн зарим үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжүүлэх ажлуудаас	<ul style="list-style-type: none">ТУЗ-ийн хурлын ээлжит, ээлжит бус хурал болон хувьцаа эзэмшигчийн хурлын 2017-2023 оны материалуудыг цахим хэлбэрт шилжүүлсэн.GDNC.MN Динамик вэбсайт хийх компанид контент илгээх, бэлтгэх, засварлах ажлуудыг хийж гүйцэтгэв.Танилцуулах өдөрлөгт ашигласан QR-тай нэрийн хуудас болон стэнд, баннер, тараах материалын загваруудыг гаргаж хэвлүүлсэн.Вэбсайтад байршуулах тайлангууд, хуучин загвартай байсан бүтэц, мэдээлэл, дүрэм журмын файлуудыг шинэ загвартай болгон засварласан.Бизнес оновчлол хөтөлбөрийн танилцуулга бэлтгэж гаргасан.

Архив	
	<ul style="list-style-type: none">2023 оны А,Б тушаал болон ирсэн, явсан албан бичгүүдийг архив албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журамыг үндэслэн үдэж хавтасласан.
Бусад ажлууд	<ul style="list-style-type: none">Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх тушаал, албан тоот зэргийг тухай бүр гүйцэтгэх захирлаар хянуулж, батлуулсан.2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг төлөвлөж батлуулсан.Төлөвлөгөөний дагуу холбогдох хэлтсүүдээс сар бүрийн тайланг нэгтгэж гүйцэтгэх захиралд танилцуулсан.Шаардлагатай тохиолдолд компанийн /итгэмжлэлгдсэн/ төлөөлөгчөөр шүүх хуралд оролцож байсан./Тус ажлыг хуулийн хэлтсийн тайланд хавсаргав./2023 оны 8 дугаар сард төлөөлөн удирдах зөвлөлийн даргад хагас жилийн ажлаа тайлагнав.Удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу ажиллав.





ХУУЛИЙН ХЭЛТЭС

Компанийн хуулийн хэлтэсийн зүгээс санхүүгийн болон мэргэжлийн үйл ажиллагааг зохицуулахад шаардлагатай хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, компанийн болон харилцагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр 2023 онд дараах ажлуудыг хийсэн байна.

Үйл ажиллагааны нэр	Хийгдсэн ажлууд
Албо ХХК	<ul style="list-style-type: none">5 удаагийн шүүх хурал болж, 2 тал эвлэрэхээр харилцан тохиролцсон.
Эвлэрэл	<ul style="list-style-type: none">Сүхбаатар дахь иргэний хэргийн анхан шатны шүүхэд 9 дуудан ирүүлэхээс 9 дээр гэрээ байгуулж эвлэрсэн.
Зөрчилтэй үл хөдлөхийг хураах	<ul style="list-style-type: none">Төлбөрийн болон гэрээний зөрчилтэй үл хөдлөхийг түрээслэгчдэд мэдэгдэл хүргүүлсэн.
Авлага/өглөг	<ul style="list-style-type: none">
Хуулийн зөвлөгөө	<ul style="list-style-type: none">Гэрээтэй харилцагч болон гэрээ цуцласан харилцагч нартай давхардсан тоогоор 1314 үулзаж хуулийн зөвлөгөө өгсөн.
Бусад	<ul style="list-style-type: none">Ч.Чинбатын 4 удаагийн шүүх хуралд оролцсон дараагийн шатны арга хэмжээ болох нэхэмжлэлийг тус шүүхэд гаргаж байгаа.Компанийн дансыг битүүмжилснийг үл хөдлөх хөрөнгөөр сольж, битүүмжийг цуцлуулсан.





ГАДААД ХАРИЛЦААНЫ ХЭЛТЭС

ГАДААД УЛСАД ХИЙГДСЭН АЙЛЧЛАЛ	
2023.03	Гүйцэтгэх захирал Д.Санжаа БНХАУ-ын Эрээн хотноо хийсэн ажлын айлчлал
2023.05.15-19	ТУЗ-ийн даргын БНХАУ-ын Тяньжин хотноо хийсэн ажлын айлчлал
2023.08.18-21	ТУЗ-ийн даргын БНХАУ-ын Тяньжин хотноо хийсэн ажлын айлчлал
2023.09.06-13	ТУЗ-ийн даргын БНХАУ-ын Тяньжин хотноо хийсэн ажлын айлчлал
2023.11.12-17	ТУЗ-ийн даргын БНХАУ-ын Тяньжин хотноо хийсэн ажлын айлчлал
2023.12.03-08	ТУЗ-ийн даргын БНХАУ-ын Тяньжин хотноо хийсэн ажлын айлчлал

Гадаад төлөөлөгчдийн Монгол улсад хийсэн айлчлал	
2023.08.11-18	Tianjin Japan болон мод үржүүлгийн компанийн төлөөлөгчдийн Монгол улсад хийсэн айлчлал
2023.09.04-09	Монгол улсаас Иран Улсад суугаа өргөмжит консул ноён Арманы Монгол улсад хийсэн ажлын айлчлал
2023.10.08-12	БНХАУ-ын Тяньжин хотын Жунжинь барилгын материал үйлдвэрлэлийн компанийн төлөөлөгчдийн Монгол улсад хийсэн айлчлал





ГАДААД ХАРИЛЦААНЫ ХЭЛТЭС

ГАДААД ГЭРЭЭ ХЭЛЦЭЛ	
2023.03.16	Мод үржүүлэг ногоон байгууламжийн чиглэлээр хамтран ажиллахаар Tianjin Japan олон улсын бизнесийн групптэй “Хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулав.
2023.03.16	Ямааны ноолуурын чиглэлээр хамтран ажиллахаар Хэбэй мужийн Shizhang ноолуурын бүтээгдэхүүний компанитай “Хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулав
2023.03.22	Олон улсын худалдааны чиглэлээр болон гурван улсын хамтарсан компани байгуулахаар БНХАУ-ын Эрээн хотын Beisite хүнд машин механизмийн тоног төхөөрөмжийн компани, ОХУ-ын МН лайт компаниудтай “Хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулав.
2023.05.24	Барилгын материалын худалдаа болон орчин үеийн үгсармал орон сууцны чиглэлээр хамтран ажиллахаар БНХАУ-ын Тяньжин хотын Жунжин барилгын материалын компанитай “Хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулав.
2023.06.28	ОХУ-ын “НПО ЭМ-Центр” ХХК-тай 3,500,000 рублийн ногоон дэлхий зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулав.
2023.08.18	Хөшигийн хөндийн санхүүгийн төвийн бүтээн байгуулалтын техникийн даалгаврыг гүйцэтгүүлэхээр Казахстан Улс дахь Colliers компанитай 134,000 ам.долларын зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулав.
2023.12.06	Ухаалаг ус шүүгчийг Монгол Улсад нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар БНХАУ-ын Тяньжин хотын TEDA ухаалаг усны компанитай гэрээ байгуулав.
2023.12.07	Усны шугам хоолойн ухаалаг холбогч болох BONLOK бүтээгдэхүүнийг Монгол Улсад худалдаалах чиглэлээр “Sino-Swiss Bonlok pipe connection technology” компанитай гэрээ байгуулав.
2023.11.22	БНХАУ-ын Тяньжин хотноо Монгол-Оросын олон улсын худалдааны Тяньжин компани байгуулагдаж, анхны төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаа зохион байгуулав.





Тайлан

ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХЭЛТЭС

Ногоон хөгжил үндэсний нэгдэл ХК-ийн гэрээтэй харилцагчдыг хүлээн авч уулзаж орон сууцжуулах төсөл хөтөлбөрийн үйл явцын талаар мэдээлэл өгөх, харилцагчдын асуудлыг холбогдох албан тушаалтнаар дамжуулан шийдвэрлүүлэх, санал гомдлыг хүлээн авах зэрэг өдөр тутмын үйл ажиллагаанд оролцон ажилладаг. Мөн 72777227 утсанд ирсэн дуудлагад хариулж, шаардлагатай үед харилцагчидтай дуудлага болон мессежээр холбогдон хэлтсийн төлөвлөгөөт ажлаа явуулдаг.

Харилцагчдын нэгдсэн гэрээ бүртгэл

2023 оны 4 дүгээр сар - Нийт харилцагчдын гэрээг шүүж харилцагчдын дэлгэрэнгүй мэдээлэлтэй нэгдсэн бүртгэлийг бий болгов. Дараах Төрийн бус байгууллагуудын нийт 650 харилцагч компанид бүртгэлтэй.

- Багш нарын “Шинэ зуун зөвлөлдөх зөвлөл” ТББ
- Эмч нарын “Цэгц танхим” ТББ
- Гэрлийн өргөө ТББ
- Найрамдал зуслан “Урмын дээд оргил” ТББ
- ДБЭТ ажилчид

Ирсэн өргөдөл, санал гомдлын тоон мэдээлэл

Гэрээ цуцлах хүсэлт	Бусад	Нийт
306	281	25





Тайлан

ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХЭЛТЭС

Хүлээн авч уулзсан болон ирсэн утасны дуудлага давхардсан тоогоор:

Биечлэн ирсэн	Ирсэн дуудлага
2701	1867

Байранд орсон харилцагчид

2023 оны 6, 9 дүгээр саруудад байранд орсон харилцагчидтай утсаар холбогдож тэдний мэдээллийг шинэчлэх, дутуу төлөлт нэхэмжлэх ажил хийгдэв. /Хос цайз, Тулга хотхон, Гарден 16/

Томилолт – Багануур дүүрэг

2023.06.26-2023.06.28-ний хооронд ХОНХХ-ээс Ш. Нарангарвуу, У.Янжмаа нар Нийслэлийн Багануур дүүрэгт хувьцааг орон орон сууц төсөл хөтөлбөрийн танилцуулга бүртгэл хийхээр томилолтоор ажиллав. Нийт 34 гэрээний дугаар тараагдаж 30 харилцагч бүртгүүлсэн.

Цахимаар харилцах тогтолцоо

2023 оны 3-р улирлаас компанийн байранд орсон болон сар бүрийн төлөлтөө хийгээд явж байгаа, буцаалт хийсэн харилцагчдыг фэйсбүүкийн группт нэгтгэж энэ нь цаашдаа цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, түгээх, санал хүсэлт хүлээн авах зорилготой. Цахим орчинд нэгтгэснээр компани дээр ирэх харилцагчдын төвлөрөл багассан.

Давуу эрхийн хувьцаа – Гэрээ шинэчлэлт

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр охин компанийн давуу эрхийн хувьцаа гарснаар төсөлд хамрагдан сар бүрийн төлөлтөө хийж буй харилцагчдын гэрээг Өргөө ногоон хөгжил ХХК-тай хийж эхлэв. 2023 оны 08 дугаар сарын 03-ны өдрөөс харилцагчдын төлөлтийг СЭХ-с ангилан гаргасны дагуу компаниас цагийн хуваарь гарган дуудаж дараах гэрээнүүдийг хийгээд байна. (1) Гэрээ дүгнэх акт, (2) хувьцаа худалдах, худалдан авах гэрээ, (3) эрх шилжүүлэх гэрээ, (4) мастер гэрээ, (5) опцион гэрээ, (6) Стандарт инвестмент ХХК ҮЦК-ийн харилцагчийн данс нээлгэх гэрээг хийж, шаардлагатай гэрээнүүдийг нотариатаар батлуулан одоогийн байдлаар нийт 300 харилцагчидтай гэрээ байгуулсан байна.





Тайлан

СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

№	Үйл ажиллагааны нэр	Хийгдсэн ажлууд
1	ТУЗ болон Судалгаа хөгжлийн газрын оффисын тохижилтын ажил	<ul style="list-style-type: none">7 - 8 сар хүртэл оффисын дотор ханын заслын ажил хийгдэж дуусгасан.8 -10 сарын хооронд оффисын тавилгыг сонгож, ажиллах нөхцөл бүрдсэн. 10-11 сард интерьерт шаардлагатай цэцэг, хөшиг болон бусал шаардлагатай зүйлсийг бүрдүүлсэн.
2	5 бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө	<ul style="list-style-type: none">8 сард Монгол лсын газар нутгийг бүсчлэн 5 хэсэгт хуваасан9-11 сард бүсчилсэн нутаг дэвсгэрт өртөөлөн ногоон отог, ногоон хүрээ, ногоон хотуудыг тархаан байршуулсан 11-12 сард тухайн бүс бүрт төлөвлөгдөх айл өрх болон аялал жуулчлалын хүрээнд боломжит тоо хэмжээг тооцон ерөнхий байдлаар гаргасан. (Цаашид энэ тоо хэмжээ тухайн бүс нутагт хэрэгжих төсөл хөтөлбөрүүдээс хамаарч нарийвчлалтай гаргана.)
3	Улаанбаатар хотын судалгааны ажил	<ul style="list-style-type: none">8-10 сард 20,000 айл өрхийг Улаанбаатар хотод Хувьцаат орон сууц төсөл хөтөлбөрт тусгасан. (Чөлөөт бүсэд шинээр төлөвлөх, хотын зах орчмын сууцны хэсгүүдэд дахин төлөвлөлт хийх, бусад төсөл хөтөлбөрийн хүрээнд орон сууцжуулах гэсэн 3 ангилал гаргасан) 10-11 сард дүүрэг бүрт судалгаа хийж бусад хийгдэж буй гадны төсөл хөтөлбөрийн судалгааг танилцуулсан.
4	Ерөнхий төлөвлөлтийн скиз зураг	<ul style="list-style-type: none">9-10 сард газрын мэдээлэл авч, ерөнхий төлөвлөлт тал дээр Sketchup програм дээр ажилласан.10-12 сард тухайн газартай холбоотой татвар болон гэрээний тал дээр хариуцан ажиллаж уулзалт хийж ажиллаж байна. 12 сард ерөнхий скиз зургийг бэлтгэн Багахангай дүүргийн захиргаагд танилцуулахад албан бичгийн хамт хүргүүлсэн.
5	Ногоон хүрээ, Ногоон отогийн схем зураглал	<ul style="list-style-type: none">9-10 сард ногоон отогийн ерөнхий бүтцийг Sketchup програм дээр гаргасан. (Төсөл хөтөлбөр хэрэгжих бүрт тухайн газар нутагт тохирсон ерөнхий төлөвлөлтийг ногоон отогийн ерөнхий схем зураглалын бүтцийн дагуу хийгдэнэ) 11 сард ногоон хүрээний схем зураглал гаргасан.





Тайлан

САНХҮҮ

Зорилго: Ногоон хөгжил үндэсний нэгдэл ХК болон түүний охин компанийн санхүү бүртгэлийн үйл ажиллагааг шударгаар, Монгол Улсын болон олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв бүртгэж, удирдлага болон хувьцаа эзэмшигчдэд үйл ажиллагааны санхүүгийн тайланг гаргаж өгч байна.

Зорилт: Ногоон хөгжил үндэсний нэгдэл ХК болон түүний охин компанийн санхүү бүртгэлийн үйл ажиллагааг шударгаар, Монгол улсын болон олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв бүртгэж, удирдлага болон хувьцаа эзэмшигчдэд үйл ажиллагааны санхүүгийн тайланг гаргаж өгч байна.

- **“Би Ти Солюшн” ХХК-тай хамтран ажиллаж Шинэ программ нэвтрүүлж, программын эхлэлийн балансыг тохируулав.**
- ✓ 2023 онд нийт 4 тэрбум гаруй төгрөгний мөнгөн орлого, зарлагыг тус тус 2 нягтлан бодогч шивэлт хийж нийт 17000 ширхэг гүйлгээг оруулсан болно.
- ✓ Мөнгөн гүйлгээний гэрээ, Түрээсийн гэрээ болон хамтран ажилладаг байгууллагуудын гэрээний бүртгэл болох 800 орчим харилцагчийн бүртгэл, гэрээний бүртгэл хийж баталгаажуулсан.
- ✓ Байгууллагын гэрээлэгч нарыг байранд орсон, буцаалтын өргөдөл өгсөн, үргэлжилж буй гэрээлэгчийн 10 нэр төрлөөр тусган программ-д тодорхой болгон оруулсан
- ✓ Харилцагч тооцоо нийлэхээр ирэх үед сар бүрийн орлого шивэлт бүрэн байх тохиолдолд программаас шууд хэвлэгдэн гарна.
- ✓ Нийт 85 санхүүгийн данс программд үүсгэсэн. Дээрх санхүүгийн программын сигментээр өдөр тутамд байгууллагын санхүүгийн бүртгэлийг бүртгэлжүүлж байна. Мөнгө орлогоо авлага, өглөгөөр бүртгэлжүүлэн түүнээс дараагийн зардал болон бусад харилцах дансаар гүйлгээ хийгдэж бланс тэнцэл хийгдэнэ.





Тайлан

САНХҮҮ

РЕЛАЭНС СЕКЮРИТИЗ АУДИТ ХХК-ийн зөвлөмжийн дагуу

Урьдчилж орсон орсон орлого дансанд бичилт хийгдэж тайлагнасан 11,835,155,401 төгрөгөөр бүртгэсэн тоог урт хугацаат өглөг дансанд бүртгэх зөвлөмж өгсний дагуу бүртэл хийсэн. Ингэснээр Эргэлтийн өр төлбөрийн хэмжээ буурсан үзүүлэлттэй гарсан.

➤ **Бусад ажил үүргүүд**

- ✓ 2021 оны 12-р сарын 14 ний өдөр 1/05 тоот гэрээний дагуу **Золач ХХК** Олон улсын үнэлгээний стандартууд, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 274/240 тоот тушаалаар батлагдсан “Үнэлгээчний ёс зүйн дүрэм зэрэг дотоодын хууль журмын хүрээнд хийж гүйцэтгэн, 3,3 тэрбум төгрөгний Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-дээр гаргасан.
- ✓ Төслийн хүрээнд байгууллагын нэр дээр үйл ажиллагаанд зориулан 5 ширхэг 110 сая төгрөгний үнэ бүхий авто машин худалдан авч хөрөнгөөр бүртгэлд тусгасан.
- ✓ 2022 оны 2-р сарын 10 ний өдөр Тэргэл менежмент ХХК-компанийн бүртгэлийг сайжруулах, маркетинг менежментийн төлөвлөгөө, НББ-ийн бодлогын бичиг баримт боловсруулах ажлуудаар гэрээ байгуулан ажиллаж, НБББББ бичиг боловруулан гаргасан.
- ✓ Ногоон хөгжил Үндэсний Нэгдэл ХК-с санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй Аудитын байгууллагаар хараат бус Аудитын дүгнэлт хийлгэж тайлан баталгаажуулсан.
- ✓ Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр гүйцэтгэж ирсэн.
- ✓ Олон нийттэй харилцах хэлтэстэй хамтран хүсэлт илгээсэн харилцагчийн дагуу Тооцоо нийлэх, буцаалтийн хүсэлт авах ажлуудыг бүртгэлд оруулж санхүүгийн нэгтгэлд оруулсан.
- ✓ Хуулийн хэлтэстэй хамтран Шүүхэд ирсэн болон өгсөн нэхэмжлэхүүдтэй тооцоо тулах, уулзалт хийх, нэхэмжлэх гаргах ажлыг хийж ирсэн.
- ✓ 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан санхүүгийн программ-д тоон дүнг нэгтгэн хаалтын бичилт хийж Цалин хөдөлмөрийн хөлсний тайлан илгээх , ХАОАТ -тайлан илгээх ,Санхүүгийн тайлан илгээх энэ нь 2023 оны 01-р сарын 01-ний өдрөөс 1-р сарын 25 өдөр гэхэд эцсийн байдлаар бэлтгэн гаргах 2-р сарын 10-ний өдрөөр тайлан илгээж дуусган 14 хоногын хугацаанд Аудит орох үүгээр 2022-12-р сарын ажил бүрэн хаагдах болно.



САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,078,303,291.23	53,826,113,374.29
2.1.1.1	Дансны өглөг	2,553,896,983.36	2,786,437,129.36
2.1.1.2	Цалингийн өглөг	5,151,078.40	0.00
2.1.1.3	Татварын өр	33,157,987.62	50,644,008.57
2.1.1.4	НДШ - ийн өглөг	16,098,902.04	67,007,752.88
2.1.1.5	Банкны богино хугацаат зээл	612,548,799.00	697,143,171.00
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	0.00	
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	643,350.00	156,229,756.67
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,221,497,100.42	3,757,461,818.48
2.1.2.1	Урт хугацаат зээл	657,715,000.00	0.00
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	9,549,504,419.04	6,693,925,749.41
2.1.2.5		0.00	0.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	10,207,219,419.04	6,693,925,749.41
2.2	Өр төлбөрийн нийт дүн	13,428,716,519.46	17,145,313,317.30
2.3	Өмч		0.00
2.3.1	төрийн		
2.3.2	хувийн	5,205,601.00	5,205,601.00
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-1,355,618,829.23	36,675,594,455.99
2.3.10		0.00	
2.3.11	Эздийн өмчийн дүн	-1,350,413,228.23	36,680,800,056.99
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	<u>12,078,303,291.23</u>	<u>53,826,113,374.29</u>



ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН



ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН									2023.12.31
№	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	5,205,601.00	-	-	-	-	-	-	-
								1,350,413,428.32	(1,345,207,827.32)
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-	-	-
2	Залруулсан үлдэгдэл	5,205,601.00	-	-	-	-	-	(1,350,413,428.32)	(1,345,207,827.32)
3.0	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	(973,992,115.69)	(973,992,115.69)
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
5	Өмчид гарсан өөрчлөлт	45,000,000.00	-	-	-	-	-	45,000,000.00	45,000,000.00
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	(6,000,000.00)	-
8	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	5,205,601.00	-	-	-	-	-	36,675,594,455.99	36,680,800,056.99





Тайлан

САНХҮҮ

Худалдах, түрээслэх зориулалтаар авсан 2021 оны жилийн эцсийн байдлаар худалдан авалт хийгдсэн 6,399,096,250 төгрөг байна. Энэ нь баримтаар нотлогдсон мөн 2022 оны 930,653,704 төгрөгөөр орон сууц худалдан авалт хийж нийт 2,787,544,681.82 төгрөг борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгө дансанд бичилтээр тусгав, захиалсан болон худалдан авсан байрны Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ баталгаажсан хөрөнгө болох 2,578,367,004.23 төгрөг Үндсэн хөрөнгөөр бүртгэн, захиалсан байрны төлбөрийг Урьдчилж төлсөн зардал тооцоонд 4,319,053,564 төгрөг бүртгэн тайланд тусгасан.

ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	2020.12.31	2021.12.31	2022.12.31
Дансны өглөг	3,926,677,000.00	0	2,553,896,983.36
Цалингийн өглөг	22,350,820.70	3,400,000.00	5,151,078.40
Богино хугацаат өглөг			643,350.00
Татварын өр	-	-	33,157,987.62
НДШ-ийн өглөг	-	-	16,098,902.04
Богино хугацаат зээл	-	-	612548799
Ноогдол ашгийн өглөг	-	-	
Урьдчилж орсон орлого	-	9,285,570,543.60	
Бусад богино хугацаат өр төлбөр	193,045,900.00	191,000,000.00	
Эргэлтийн өр төлбөр	<u>4,142,073,720.70</u>	<u>9,479,970,543.60</u>	<u>3,221,497,100.42</u>
Урт хугацаат зээл	-		657,715,000.00
Урт хугацаат өглөг	-		9,549,504,619.04
Урт хугацаат өр төлбөр			<u>10,207,219,619.04</u>
Энгийн хувьцаа	5,205,600.00	5,205,600.00	5,205,601.00
Нэмж төлөгдсөн капитал			
Тайлант үеийн Хуримтлагдсан ашиг	-159,868,500.00	-821,352,194.66	-534,266,834.66
Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг	-154,662,900.00	-816,146,593.66	-821,352,194.66
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	<u>-3,987,410,820.70</u>	<u>-8,663,823,949.94</u>	<u>-1,350,413,428.32</u>



Тайлан

САНХҮҮ

Нийт авлагын мэдээлэл 2023 оны 12 сарын
31-ний байдлаар

2,770,729,550



2023
Тайлан



“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

№ ...

Улаанбаатар хот

**НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХГҮЙ ТУХАЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ГАРГАСАН ШИЙДВЭРИЙГ ТАНИЛЦУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 46.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7.7.2, Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ**:

1. 2023 онд ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ын 2024 оны 2-р сарын 18-ний өдрийн 1 тоот тогтоолийг зөвшөөрсүгэй
2. 2024 онд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийг эрчимжүүлж, ашигтай ажиллах ногдол ашиг хувиарлах боломжийг бүрдүүлж ажиллахыг ТУЗ-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Ж.ЖАРГАЛСАЙХАН



**“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 4 дүгээр
сарын 30 -ны өдөр

№ ...

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ХУВААХ ТУХАЙ

Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 51, 62 дугаар зүйл, Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн нэг бүр нь 1 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт гаргсан 5,205,600 ширхэг энгийн хувьцааны нэгж хувьцаа бүрийг 100 хувааж нэг бүр нь 1 мөнгөний нэрлэсэн үнэтэй нийт 520,560,000 ширхэг хувьцаа болгосугай.
2. Хувьцаа хуваахтай холбогдуулан компанийн дүрэм дэх нийт зарласан хувьцааг 100,520,560,000 ширхэг болгон нэмэгдүүлж, дүрмийн өөчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлсүгэй.
3. Хувьцаа хуваахтай холбогдуулан “Хувьцаа хуваах үйл ажиллагааг гүйцэтгэх журам”-ыг __ хавсралтаар, “Хувьцаа хуваах төсөл”-ийг __-р хавсралтаар баталсугай.
4. Энэхүү тогтоол гарч байгаатай холбогдуулан “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн дүрмийн төслийг __ -р хавсралтаар өөрчлөн найруулахыг зөвшөөрсүгэй.
5. Санхүүгийн зохицуулах хорооноос Хувьцаа хуваах шийдвэрийн зөвшөөрөл гармагц Компанийн дүрмийн төслийн өөрчлөлтийг Улсын бүртгэлийн газраар батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ж.Жаргалсайхан/-д даалгсагуй.
6. Энэхүү тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ж.Жаргалсайхан/-д даалгсагуй.

ХУРЛЫН ДАРГА

Ж.ЖАРГАЛСАЙХАН

“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ХУВААХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ГҮЙЦЭТГЭХ ЖУРАМ

1.1. Энэ журмаар “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК /цаашид үнэт цаас гаргагч гэх/ нэгж хувьцааг хуваах үндэслэл, зорилго, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцаа хуваах шийдвэр гаргах, хуваасан хувьцааг Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх, төвлөрсөн хадгаламжийн байгууллагад хуваасан хувьцааг хадгалуулах, эсрэг саналтай хувьцаа эзэмшигчид шаардах эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журам нь Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагаас баталсан дүрэм, журамтай нийцэх бөгөөд хууль, журамтай зөрчилдсөн тохиолдолд хуулийн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

1.3. Үнэт цаас гаргагчийн хувьцаа хуваах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлаар, хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхийн олонхийн саналаар саналаар шийдвэрлүүлж, хууль зүйн дүгнэлтийг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр гүйцэтгүүлж, дүгнэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах ажлыг Гүйцэтгэх захирал хариуцан ажиллана.

1.4. Үнэт цаас гаргагчийн хувьцаа хуваах, нөхцөл, хувьцааг хөрвүүлэх тооцооллыг Гүйцэтгэх удирдлагаас боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлуулна.

1.5. Нэгж хувьцааг хувааж, нэмж гаргасан хувьцааг Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх, бичиг баримтын бүрдлийг хангах, нэмэлт баримт бичиг шаардсан нөхцөлд хөндлөнгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас гаргуулах, тайлбар мэдээлэл өгөх ажлыг Гүйцэтгэх удирдлага хариуцан ажиллана.

ХОЁР. ХУВЬЦАА ХУВААХ АЖИЛЛАГАА, ТҮҮНД ОРОЛЦОГЧДЫН ЭРХ ҮҮРЭГ

2.1. Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгон гаргасан нэгж хувьцааг Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийг үндэслэн хувьцаа хуваах ажиллагааг гүйцэтгэх бөгөөд үнэт цаас гаргагч нь хувьцаа хуваах ажиллагааг дараах зорилгын аль нэгийг хангах зорилгоор хэрэгжүүлнэ.

2.1.1. Арилжаа эрхлэх байгууллагаар арилжаалагдаж буй гаргасан Хувьцааны тоо ширхэгийг нэмэгдүүлж хөрвөх чадварын түвшинг дээшлүүлэх;

2.1.2. Стратегийн хөрөнгө оруулагч болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог бууруулах, зах зээлийг идэвхжүүлэх;

2.1.3. Үнэт цаас гаргагчийн арилжаа эрхлэх байгууллагад арилжаалагдаж хувьцаа үнэ ханш хэт өсч, бодит үнэ цэнээ алдаж, хөөс үүссэн нөхцөлд нэгж хувьцаа хувааж, бодит үнэ цэнийг тогтоох;

2.1.4. Зах зээлд хувьцааны тоо хэмжээг нэмэгдүүлэх замаар эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх.

2.2. Үнэт цаас гаргагч хуулийн этгээд Гүйцэтгэх удирдлагаас арилжаа эрхлэх байгууллагад арилжаалагдаж буй хувьцааны үнэ ханш, хөрвөх чадварын үзүүлэлт, хувьцаа эзэмшигчдийн төвлөрөл, бүтцийн мэдээллийг холбогдох байгууллагаас жил тутам гаргуулан авч судалж үзээд, эрэлт, нийлүүлэлтийн талд зөрүү үүсч, үнэ ханш хэт өссөн нөхцөлд Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд хувьцаа хуваах эсэх талаарх саналыг оруулж хэлэлцүүлнэ.

2.3. Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирлаас хувьцаа хуваах чиглэлээр оруулсан санал үндэслэлтэй гэж үзвэл хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хуралд танилцуулах ажлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад өгч, тогтоолын төсөл, хувьцаа хөрвүүлэх тооцоолол, судалгааг бэлтгэн хувьцаа эзэмшигчдийн хурлын зараар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

2.4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хуралд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга компанийн хувьцааг хуваах төсөл, тогтоолын төслийг танилцуулж, хэлэлцүүлж, хувьцаа эзэмшигчдийн олонхийн зөвшөөрлийг авснаар дээрх ажиллагааг гүйцэтгэх нөхцөл бүрдэнэ.

2.5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлаар үнэт цаас гаргагчийн хувьцаа хуваахаар шийдвэр гаргасан нөхцөлд Төлөөлөн удирдах зөвлөлөөс дээрх ажиллагааг гүйцэтгэх удирдлагад даалгана.

2.6. Гүйцэтгэх удирдлагаас хувьцаа хуваах аргаар гаргасан хувьцааг Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэхтэй холбоотой бичиг баримтын бүрдлийг хангах, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч байгууллагатай хууль зүйн дүгнэлт гаргуулах гэрээг байгуулж, дүгнэлтэд шаардлагатай мэдээллийг гаргаж өгнө.

2.7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хуралд оролцсон, оролцож чадаагүй хувьцаа эзэмшигчээс хувьцаа хуваах шийдвэрийг эс зөвшөөрсөн нөхцөлд Компанийн тухай хуульд заасан шаардах эрх хэрэгжүүлэх эсэх асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэж, шаардах эрх хэрэгжүүлэхийг хязгаарлаж болно.

2.8. Үнэт цаас гаргагчийн хувьцааг хувааснаар бутархай үлдэгдлийг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон үнээр эргүүлэн худалдаж авах бөгөөд шаардлагатай санхүүжилтийг компаниас гаргана.

2.9. Хувьцаа хуваах ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч хуулийн этгээд оролцож, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д заасан агуулга, нөхцлийн хүрээнд гаргаж, зөвлөгөө үзүүлэхээр байгуулсан гэрээнд заасан эрх үүргийг хүлээж ажиллана.

2.10. Хувьцаа хуваах ажиллагаанд хийгдсэн хууль зүйн дүгнэлт нь хэлбэр, агуулгын шаардлага хангаагүй, Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагаас

дүгнэлттэй холбоотой НЭМЭЛТ тодруулга, мэдээлэл шаардаж, дүгнэлтийг дахин гаргуулахыг мэдэгдсэн нөхцөлд үйлчилгээ үзүүлэх гэрээг цуцлах,

дахин дүгнэлт гаргуулах, үйлчилгээний төлбөрийн хэмжээг бууруулах арга хэмжээг Гүйцэтгэх удирдлагаас авч хэрэгжүүлж болно.

ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦААГ БҮРТГҮҮЛЖ, ХАДГАЛУУЛАХ

3.1. Компанийн гүйцэтгэх захирал хувьцаа хуваах хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, холбогдох бичиг баримтыг арилжаа эрхлэх байгууллагаас баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын агуулгад нийцүүлэн бэлтгэж, арилжаа эрхлэх байгууллагад бичиг баримтыг бүрдэл хангагдсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор хүргүүлнэ.

3.2. Арилжаа эрхлэх байгууллагаас үнэт цаас гаргагчийн хувьцаа хуваах бичиг баримтыг хянаж, нэмэлт баримт, тодруулга шаардсан нөхцөлд нэн даруй гаргах ажлыг гүйцэтгэх удирдлага хариуцан гүйцэтгэж, арилжаа эрхлэх байгууллагын шийдвэрээр зөвшөөрсөн нөхцөлд арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх ажиллагааг дуусгавар болно.

3.3. Арилжаа эрхлэх байгууллагаас хувьцаа хуваахыг зөвшөөрч, хувьцааны тоо хэмжээнд өөрчлөлт оруулсан шийдвэр гаргасан даруй ажлын 3 хоногт багтаан Санхүүгийн зохицуулах хорооноос "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу холбогдох бичиг баримтыг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж, арилжаа эрхлэх байгууллагын шийдвэр, дүгнэлтийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн эсэхийг гүйцэтгэх удирдлагаас тодруулах ажлыг гүйцэтгэнэ.

3.4. Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаас гаргагчийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулж, нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхтэй холбоотой албан бичгээр нэмэлт тодруулга, мэдээлэл шаардсан нөхцөлд гүйцэтгэх удирдлагаас холбогдох мэдээллийг нэн даруй гаргах ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

3.5. Санхүүгийн зохицуулах хорооноос хувьцаа хуваах ажиллагаанд хөндлөнгийн хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч хуулийн этгээдээс боловсруулсан дүгнэлттэй холбоотой тодруулга мэдээллийг шаардаж, тайлбар өгөхийг шаардсан нөхцөлд гүйцэтгэх удирдлага, хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч байгууллага гэрээгээр хүлээсэн үүргийн хүрээнд биечлэн очиж тайлбар, тодруулга өгч ажиллана.

3.6. Арилжаа эрхлэх байгууллага болон Санхүүгийн зохицуулах хороонд хувьцаа хувааж, хувьцааны тоонд өөрчлөлт оруулахтай холбоотой бүрдүүлэх бичиг баримтын бүрдэлд Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга хяналт тавьж ажиллана.

3.7. Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаас гаргагчийн хувьцаа хувааж, хувьцааны тоо хэмжээнд өөрчлөлт оруулах асуудлыг хянаж үзээд өөрийн хуралдаанаар хэлэлцүүлэх нөхцөлд компанийн төлөөлж, Гүйцэтгэх удирдлага оролцож, тайлбар, тодруулгыг өгнө.

3.8. Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолоор үнэт цаас гаргагчийн хувьцаа хувааж, хувьцааны тоонд өөрчлөлт оруулах шийдвэрийг гаргасан даруй ажлын 3 хоногт багтаан үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагатай хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцаа тоо хэмжээнд өөрчлөлт оруулах, хадгалалттай холбоотой гэрээг байгуулах ажлыг Гүйцэтгэх удирдлага хариуцан гүйцэтгэнэ.

3.9. Хувьцаа хувааж, хувьцааны тоо хэмжээнд өөрчлөлт оруулах бүртгэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад хийгдэх хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг түр хугацаагаар зогсоохтой холбоотойгоор хувьцаа эзэмшигч хувьцаагаа худалдах, хөрөнгө оруулагч худалдан авах боломжгүй болох талаарх мэдээллийг үнэт цаас гаргагч өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд түгээнэ.

3.10. Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаас гаргагчийн хувьцаа хуваахтай холбоотой арилжааг түр зогсоосон улсын байцаагч арилжааг сэргээж, арилжаа эрхлэх байгууллагаас хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлсэн өдрөөс хойш ажлын 2 хоногт багтаан компанийн дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийн төслийг улсын бүртгэлийн газарт бүртгүүлнэ.

ДӨРӨВ. ДОТООД МЭДЭЭЛЭЛ ЭЗЭМШИГЧИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

4.1. Үнэт цаас гаргагчийн хувьцаа хувааж, хувьцааны тоо хэмжээнд өөрчлөлт оруулах шийдвэр гарч, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэх хугацаанд үнэт цаас гаргагчийн дараах этгээдүүд дотоод мэдээлэл эзэмшигч болно. Үүнд:

4.1.1. Нийт гаргасан хувьцааны 10 хувиас дээш хувийг эзэмшигч хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд, тэдгээрийн гэр бүлийн гишүүд;

4.1.2. Энэхүү журмын 4.1.1-д заасан хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, нэгдлийн оролцогчид;

4.1.3. Хувьцаа хуваах ажиллагаанд ажил, үүргийн дагуу оролцож, Үнэт цаас гаргагчтай холбоотой мэдээлэл эзэмшиж буй албан тушаалтан, мэргэжилтэн;

4.2. Дотоод мэдээлэл эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлаар хувьцаа хуваах шийдвэр гарч, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэх хүртэлх хугацаанд дараах ажиллагаа хийхийг хориглоно. Үүнд:

4.2.1. Дотоод мэдээллийг аливаа гуравдагч этгээдэд дамжуулах, худалдах, шилжүүлэх;

4.2.2. Бусад гуравдагч этгээдээр дамжуулан хувьцааг худалдан авах, борлуулах, ашиг олох;

4.2.3. Дотоод мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах, олон нийтэд мэдээлэл тараахгүй байх;

4.2.4. хууль, журмын дагуу дотоод мэдээлэл эзэмшигчийн хийхийг хориглосон бусад ажиллагаа.

4.3. Үнэт цаас гаргагч нь энэхүү журмын 4.1-д заасан этгээд дотоод мэдээлэл эзэмшин арилжаанд оролцсон гэж үзвэл Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэхээр Санхүүгийн зохицуулах хороонд гомдол гаргаж болно.

ТАВ.ХАРИУЦЛАГА

5.1. Энэхүү журмыг гүйцэтгэх удирдлага зөрчсөн тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаас гүйцэтгэх удирдлагад хариуцлага хүлээлгэнэ, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд зөрчсөн нөхцөлд гишүүнийг үүрэг ажлаас чөлөөлөх хүртэл арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

-000-

“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ХУВААХ ТӨСӨЛ

НЭГ. КОМПАНИЙН ХУВЬЦААГ ХУВААХ АЧ ХОЛБОГДОЛ

- 1.1 Монгол Улсын “Компанийн тухай” хуулийн 52 дугаар зүйл болон 63 дугаар зүйлд тус тус заасны дагуу 2024 оны 4 сарын 30-ны өдөр хуралдсан “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар, хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар энэхүү “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн хувьцаа хуваах төслийг хэрэгжүүлэх үндэслэл бүрдсэн болно.
- 1.2 Зорилго: Уг төслийн зорилго нь Компанийн нэгж хувьцааг хуваах, хувьцааны тоо хэмжээг нэмэгдүүлэн нэгж хувьцааны үнийг хямд болгосноор хөрөнгийн зах зээл дэх арилжааны идэвхийг нэмэгдүүлэн компанийн зах зээлийн үнэлгээг өсгөж хувьцаа эзэмшигчдийн баялгийг нэмэгдүүлэхэд оршино.

ХОЁР. ҮНДЭСЛЭЛ

- 2.1. “Компанийн тухай хууль” -ийн 51.3-т “Компани нь нэг хувьцааг тухайн төрлийн шинэ хоёр буюу түүнээс дээш тооны хувьцаанд хөрвүүлэх замаар өөрийн гаргасан хувьцаагаа хувааж болно” гэж заасны дагуу 2024 оны 4-р сарын 030-ний өдрийн “Ногоон Хөгжил Үндэсний нэгдэл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар, хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхын саналаар “Ногоон Хөгжил Үндэсний Нэгдэл” ХК-ийн нэгж хувьцааг 100 ширхэгт хуваах шийдвэр гаргав.

Хувьцааг хувааснаар арилжааны идэвх нэмэгдэж, компанийн үнэлгээ өснө гэж Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/-өөс үзэж байна. Өмнөх жилүүдэд дараах 4 компани хувьцаагаа хувааснаас хойш 3 сарын дараа компанийн зах зээлийн үнэлгээнд гарсан өөрчлөлтийг хүснэгтээр харуулав

Компанийн нэр	Хувьцаа хуваахаас өмнө		Хувьцаа хуваасны дараа		Зах зээлийн үнэлгээний өөрчлөлт
	Ханш	Зах зээлийн үнэлгээ	Ханш	Зах зээлийн үнэлгээ	
Сүү ХК	145,000	49,880,000,000	216	74,266,160,000	49%
Говь ХК	32,020	249,792,022,500	319	248,692,063,875	0%
АПУ ХК	3,970	422,480,076,541	444	472,039,011,464	12%
Таван толгой ХК	90,000	47,398,680,000	1,011	53,244,517,200	12%

2.2. Ач холбогдол: Компанийн хувьцааг хувааснаар компанид дараах ач холбогдол үүснэ. Үүнд:

- ❖ Компанийн үнэлгээ зах зээл дээр бодитоор үнэлэгдэх боломж нээгдэнэ.
- ❖ Хувьцааны ханш зохистой түвшинд хүрэх боломж бүрдэнэ
- ❖ Компанийн бүтээмжийг үнэлсэн зах зээлийн үнэлгээнд үндэслэн нэмэлт санхүүжилт татах, улмаар компанийн үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.
- ❖ Компанийн засаглал илүү сайжрах нөхцөл бүрдэнэ.
- ❖ Хувьцааг хувааж, нэмэлт санхүүжилт татсанаар компанийн санхүүгийн чадавхи нэмэгдэнэ.
- ❖ Компанийн зах зээлийн үнэлгээ болон брэндийн нэр хүндийг өсгөнө.

ГУРАВ. ХУВЬЦАА ХУВААХ ТООЦООЛОЛ

- 3.1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2024 оны 4 сарын 30-ны өдрийн ... тоот тогтоолоор компанийн нэгж хувьцааг 100 ширхэгт хуваахаар шийдвэрлэсэн.
- 3.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлийн шийдвэрт үндэслэн хувьцааг хувааснаар "Ногоон хөгжил үндэсний нэгдэл" ХК-ийн хувьцаа дараах тооцооллын дагуу нэг бүр нь 1 мөнгийн нэрлэсэн үнэтэй, нийт 520 560 000 ширхэг хувьцаа болж өөрчлөгдөнө.

	Хуваахаас	Хуваасны дараа
Нийт гаргасан хувьцаа	5 205 600 ширхэг	520 560 000 ширхэг
Нэрлэсэн үнэ	1 төгрөг	
Зарласан хувьцаа	1 005 205 600 ширхэг	105 205 600 000 ширхэг
Нэрлэсэн үнэ	1 төгрөг	1 мөнгө
Жигнэсэн дундаж	122 төгрөг	1.2 төгрөг

ДӨРӨВ. ХУВЬЦАА ХУВААХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ГҮЙЦЭТГЭХ ЖУРАМ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ТЭДГЭЭРТ ҮҮСЭХ АЧ ХОЛБОГДОЛ

- 4.1. Компани нь хувьцаа хуваах тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэн "Компанийн тухай" хуулийн 51 дүгээр зүйл болон 63 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.
- 4.2. Хувьцаа эзэмшигчдийн шийдвэрийг үндэслэн "Монгол Хөрөнгийн бирж" ТӨХК болон Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д заасны дагуу үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтээ хүргүүлж, хувьцаа хуваах асуудлыг шийдвэрлүүлнэ.
- 4.3. Компанийн хувьцааг хуваах тухай "Монголын Хөрөнгийн бирж" ТӨХК болон Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр гарч, Улсын бүртгэлд холбогдох бүртгэлийг хийлгэснээр хувьцааг хуваах үйл ажиллагаа хэрэгжиж эхлэнэ.
- 4.4. Хувьцаа хуваах үйл ажиллагаа хэрэгжиж буйтай холбогдуулан компанийн хувьцааны арилжааг эрх бүхий байгууллагын шийдвэрээр түр зогсоож болно.

- 4.5. "Монголын Хөрөнгийн бирж" ТӨХК болон "Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-д хувьцааг хуваах бүртгэлийн ажил дуусгавар болсноор компанийн хувьцааны арилжааг хэвийн явагдаж боломжтой болно.
- 4.6. Хувьцаа хуваах үйл ажиллагаатай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн зүгээс авч хэрэгжүүлэх ямарваа нэг эрх, үүрэг үүсэхгүй бөгөөд энэхүү төслийн 3.5-д зааснаар арилжаа хэвийн явагдаж эхэлсэн нөхцөлд хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшлийн хувьцаагаа биржийн арилжаагаар чөлөөтэй арилжих эрх нь нээлттэй болно.
- 4.7. Компанийн хувьцааг хувааснаар хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад дараах давуу тал, түүний ач холбогдол үүснэ. Үүнд:
 - 4.7.1. Хувьцаа эзэмшигчдийн 1 ширхэг хувьцаа бүр нь 100 ширхэг болж өөрчлөгдөн тоо хэмжээ нэмэгдэж, өндөр тогтоод байгаа нэгж хувьцааны зах зээлийн ханш 100 хуваагдан шинэчлэн тогтоосноор хөрвөх чадвар нэмэгдэнэ. Эзэмшиж буй хөрөнгө нь зах зээл дээр чөлөөтэй хөрвөх чадвартай болно.
 - 4.7.2. Эзэмшиж буй хөрөнгө нь зах зээл дээр чөлөөтэй хөрвөх чадвартай болно.
 - 4.7.3. Хувьцааны зах зээл дээрх арилжааны идэвхи нэмэгдсэнээр компанийн үнэлгээг зах зээлийн жишгээр, бодитоор үнэлэх боломжтой болж, улмаар хөрөнгө оруулагчдын өмчилж буй хөрөнгийн үнэ цэнэ өснө.
 - 4.7.4. Компанийн засаглал илүү сайжрах нөхцөл бүрдэж, улмаар хөрөнгө оруулагчдын хөрөнгийн өгөөж нэмэгдэнэ.

ТАВ. ХУВЬЦАА ХУВААХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ДУУСГАВАР БОЛОХ

- 5.1. Компанийн хувьцаа хуваах тухай төслийг компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд танилцуулан, шийдвэр гаргуулснаар компанийн хувьцааг хуваах нөхцөл бүрдэнэ.
- 5.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрийг "Монголын Хөрөнгийн бирж" ТӨХК-д болон Санхүүгийн Зохицуулах хороонд танилцуулан хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулна.
- 5.3. "Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК болон "Монголын Хөрөнгийн бирж" ХК дахь үнэт цаасны болон компанийн Улсын бүртгэлд өөрчлөлт оруулснаар уг үйл ажиллагаа дуусгавар болно.

“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ НАЙРУУЛГЫН ТОМЬЁОЛОЛ

Ногоон хөгжил үндэсний нэгдэл ХК-ийн 4 дүгээр сарын 30-ний өдөр болсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрээр компанийн дүрмэнд өөрчлөлт оруулж байна Үүнд:

Ногоон хөгжил үндэсний нэгдэл ХК- ийн 4 дугаар сарын 30-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын .. дугаар тогтоол	Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсан байдал
Хувьцаа хуваахтай холбогдуулан дүрэмд өөрчлөлт орох байдлыг дараах байдлаар тогтов.	<p>4.1. Компанийн нийт зарласан хувьцаа 100,520,560,000 ширхэг байна. Энэ дүрмийг батлах байдлаар компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 5,205,600 төгрөг байна.</p> <p>4.1.1. Нийт зарласан хувьцааны 70,520,560,000 ширхэг нь 1 мөнгөний нэрлэсэн үнэтэй энгийн хувьцаа байна. Үүнээс гүйлгээнд гаргасан энгийн хувьцаа 520,560,000 ширхэг байна.</p> <p>4.1.2 Нийт зарласан хувьцааны 30,000,000,000 ширхэг нь давуу эрхийн хувьцаа байна нэгжийн үнийг Төлөөлөн удирдах зөвлөл тогтооно. Гаргасан давуу эрхийн хувьцаа 10,000,000 ширхэг байна.</p>